

**БАТЛАВ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**БАТЛАВ**

**САНГИЙН САЙД**

**БАТЛАВ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

**Б.ЖАВХЛАН**

**Х.НЯМБААТАР**

## **НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.” гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 24.1-д зааснаас бусад Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын чиг үүргийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 оны хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д нийслэл хот нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих хөшүүргийг бий болгох, хүн амын төвлөрлийг сааруулах, нийслэлийг нэг төвт хотоос олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх, нийслэлийн дагуул хот, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгах, нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг боловсронгуй болгох зорилгоор Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

## 1.2. Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 1994 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан. Энэ хугацаанд тус хуульд Хаягжуулалтын тухай хууль баталсантай холбогдуулан нэг удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Нийслэлийн эрх зүйн байдлын талаар болон нийслэл, дүүрэг, хорооны иргэдийн Хурал, Засаг даргын чиг үүргийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиас гадна Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай болон салбарын бусад 150 гаруй хуулиар зохицуулж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын чиг үүргийг зохицуулсан эдгээр хуулиуд нь өөр хоорондоо уялдаа муутай, зарим зохицуулалт нь давхардсан, зарим тохиолдолд тодорхойгүй нөхцөл бий болгож байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж, батлах үеийн үзэл баримтлал, хэлэлцүүлгээс үзэхэд тухайн үед нийслэл хот цаашид ямар загвараар хөгжих, төр засагтай хэрхэн, ямар хэмжээнд харилцах, бусад орны жишиг ямар байгааг хөндсөн байдаг. Гэвч хуулиар зохицуулахдаа дээр дурдсан асуудлуудыг нэг мөр шийдвэрлээгүй, нийслэлийн удирдлагаас төрийн дээд болон төв байгууллагатай хэрхэн харилцах зарчим, эрх зүйн зохицуулалт сул болсноос тэдгээрийн эрх хэмжээ, бүрэн эрх давхцах, хийдэл үүсэх зэрэг нөхцөл байдал бий болж байна. Тухайлбал, төрийн захиргааны төв байгууллага нь нийслэл хотын талаар ямар бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх, нийслэл хот өөрөө ямар асуудлыг хариуцан шийдвэрлэх талаар зохицуулалт тодорхой бус байна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль анх батлагдах үед 117 хороо, 609 мянган оршин суугчтай байсан нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаа өргөжиж, 173 хороотой, 1.5 сая орчим хүн амтай, улсын хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 63 хувьтай тэнцэх аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа эрхэлдэг, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64.5 хувийг үйлдвэрлэх болтлоо өргөжин тэлжээ.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, агаар, хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр хот, суурин газарт тулгамддаг асуудал хуримтлагдаж нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байгаа тул хууль, эрх зүйн шинэ орчин бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулагдаагүй хот, нийтийн аж ахуйн асуудлуудыг оршин суугчдын төлөөлөл болсон хотын өөрийн удирдлагын байгууллага уг асуудлыг зохицуулж дүрэм баталдаг Москва, Загреб, Денвер, Варшав зэрэг бусад улсуудын нийслэл хотын жишиг зохицуулалт Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод үгүйлэгдэж байна.

Аливаа улсын нийслэл хот нь бие даасан хот гэхээсээ илүү тухайн улсын өнгө төрх болж, гадаадын жуулчдын сонирхлыг татдагийн хувьд түүний эдийн засгийн хөгжлийн бодлогыг тусгайлан авч үзэж, онцлог зохицуулалтын хүрээнд дэмжих олон улсын жишгийн дагуу Монгол Улсын нийслэл хотын хөгжлийг дэмжих төрийн үүргийн талаарх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон Монгол Улсын иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангах нь нийслэл хотын удирдлагын үүрэг боловч нийслэл хот нь иргэний энэхүү эрхийг бүрэн хангахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, санхүүгийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрх зүйн боломж зарим талаар хязгаарлагдмал байна.

Ийнхүү нийслэлд шинэ тутам үүсэж байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, нөгөө талаас нийслэл дэх давуу талыг ашиглан хөгжүүлэх замаар улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Түүнчлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн онцлогт нь тохирсон эрх зүйн зохицуулалт, чиг үүргийг нь тодорхойлохгүйгээр аймгийг нийслэлтэй, сумыг дүүрэгтэй адилтгах байдлаар удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж байгааг зарим тодорхой харилцаанд өөрчилж, нийслэл хотын эдийн засаг, нийгмийн амьдралын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагаар Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн бодлогыг шинээр тодорхойлж, эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан, сайн засаглал бүхий эдийн засаг, бизнес, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон, бүтэц, зүйл, заалтын 50-иас дээш хувьд нь өөрчлөлт орохоор байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн нэрийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай гэж өөрчлөн боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 7 бүлэг, 51 зүйлтэй байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт нь нийслэл Улаанбаатар хотын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, үйл ажиллагааны зарчим, удирдлагын эрх хэмжээ, нийслэл хотын

удирдлагаас төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон бусад этгээдтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

Нэгдүгээр бүлэгт Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нийслэл хотын зохион байгуулалтын үндэс, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэлтэй холбоотой харилцааг тусгана.

Хоёрдугаар бүлэгт нийслэл хотын чиг үүрэг, нийслэлийн дүрмийн талаар тусгана. Ингэхдээ Улаанбаатар хотын хувьд хэрэгжүүлэх тусгай чиг үүргийн хүрээнд төрийн дээд, төв байгууллага, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын дэд бүтцийг бүрдүүлэх, агаар, хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагаа, үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах, нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, иргэдийн ая тухтай амьдрах нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгана.

Мөн Нийслэл Улаанбаатар хот нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаас гадна хотын аж ахуйн асуудлаар тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр мөн тусгайлан тусгана.

Мөн энэ бүлэгт нийслэл хот өөрийн дүрэмтэй байх бөгөөд дүрмийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар тусгана. Дүрэмд тусгах асуудлыг хуулийн төсөлд тодорхой тусгах бөгөөд дүрмийн төсөлд олон нийтийн саналыг заавал авах, дүрмийг баталсны дараа иргэдэд таниулах боломж олгох зорилгоор үйлчилж эхлэх хугацааг боломжит байдлаар тусгана.

Гуравдугаар бүлэгт нийслэл хотын эдийн засгийн харилцааны талаар тусгах бөгөөд нийслэл хот нь Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон “эдийн засаг, нийгмийн цогцолбор”-ын хувьд тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэх бодит боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгана.

Ингэхдээ нийслэл хотын эдийн засгийн үндэс, нийслэлийн өмч, түүний харилцаа, нийслэлээс дотоод үнэт цаас гаргах, концесс олгох, хотын албан татвар, түүнчлэн нийслэлийг хөгжүүлэх сантай байж болох, сангийн хөрөнгийг зарцуулах тодорхой үйл ажиллагааны талаар тусгана.

Энэ бүлэгт дээрх үйл ажиллагааны зарчмын зохицуулалтыг ерөнхийд нь тусгаж, харин нарийн тодорхой харилцааг Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд тус тус заасан зарчмын дагуу Төсвийн тухай хууль, холбогдох татварын хууль, Концессын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Өрийн удирдлагын тухай хууль болон бусад хуулиудаар нарийвчлан зохицуулахаар тусгана.

Мөн энэ бүлэгт нийслэл хөрөнгө оруулалтыг тусгайлан дэмжих зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлэн нарийвчлан тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт нийслэлийн удирдлагын тогтолцоо, тэдгээрийн эрх үүрэг, ажлын уялдааны талаар тусгана. Ингэхдээ нийслэлийн удирдлагын одоогийн

тогтолцоог хэвээр хадгалахын зэрэгцээ нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн онцлог бүрэн эрхийг тодорхойлно.

Мөн нийслэл хотын тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Улаанбаатар хотын аж ахуйн харилцааны болон бусад асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Ерөнхий менежер болон дүүргийн удирдлага хооронд үүсэх харилцааг нарийвчлан тусгаж, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн зарим тодорхой бүрэн эрхийг хотын Ерөнхий менежерт шилжүүлэн хэрэгжүүлж болох талаар, нийслэлийн удирдлагын бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааны талаар тусгана.

Тавдугаар бүлэгт нийслэлээс бусад этгээдтэй харилцах харилцааны талаар тусгах бөгөөд нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хот, дүүргийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгжтэй нийслэлээс харилцах харилцааг тодорхой тусгана.

Энэ бүлэгт нийслэлийн Засаг даргаас Засгийн газартай харилцах асуудлаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна онцлог зохицуулалтай байх бөгөөд хууль санаачлахаас бусад асуудлаар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг санал гаргах, Засгийн газрын хуралдаанд оролцох, Засгийн газартай шууд харилцах талаар тусгана.

Мөн төрийн захиргааны төв байгууллагаас нийслэлтэй хамтран ажиллах, нийслэлийн оршин суугчийн нийтлэг эрх ашигт хамаарах асуудлаарх бодлого, шийдвэрийн төсөлд нийслэлийн саналыг авсан байх шаардлагыг тусгана.

Мөн энэ бүлэгт нийслэлийн удирдлагаас засаг захиргааны бусад нэгжтэй харилцах, дүүрэгтэй, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах харилцааны талаар тодорхой тусгана. Нийслэлийн оршин суугчийн эрх, үүргийг тусгах бөгөөд нийслэлийн хөгжилд тодорхой чиглэлээр иргэн, хуулийн этгээд хувь нэмэр оруулах тохиолдолд урамшуулах зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэгт нийслэл хотын дагуул хот болон эдийн засгийн тусгай бүсийн асуудлыг шинээр тусгах бөгөөд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хөгжлийг дэмжих, иргэдийн аятай таатай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийслэл хотод болон иргэн аж ахуйн нэгж байгууллагад эдийн засгийн хувьд эерэг нөлөө үзүүлэхүйц зохицуулалтыг тусгана.

Дагуул хотыг засаг захиргааны бусад нэгжийн нутаг дэвсгэр байгуулж болох бөгөөд дагуу хотыг стратегийн ач холбогдол бүхий тодорхой нөхцөлүүдийг харгалзан, хотын нэр, байршил, эдэлбэр газрын хэмжээг тусган дагуул хотыг байгуулах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарахаар зохицуулна.

Мөн энэ бүлэгт дагуул хот дахь эдийн засгийн тусгай бүсийн талаарх зохицуулалтын нарийвчлан тусгана. Эдийн засгийн тусгай бүс нь мэдээлэл технологи, инновацийн, аялал жуулчлал, соёл амралтын, хөнгөн үйлдвэрлэл, банк санхүүгийн, агаарын хөлгийн завсар үйлчилгээний, хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр дагнан, эсхүл хослуулан байгуулж болохоор тусгана. Харин нийслэлд байх тусгай бүсийн тоо нь тодорхой хязгаартай байх бөгөөд тусгай

бүс дэх татварын болон татварын бус дэмжлэгийг тусгана. Тусгай бүсэд үзүүлэх газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын зэрэг татварын дэмжлэгийг тухайлсан татварын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулна.

Дагуул хотын удирдлага, зохион байгуулалтын хувьд дагуул хотын захирагч, түүнд зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл ажиллах, харин дагуул хотын захирагч нь тусгай бүсийн захирагч байхаар тусгана.

Долоодугаар бүлэгт нийслэл хотын удирдлагаас баталсан шийдвэр нээлттэй, ил тод байх талаар, нийслэлийн гадаад хамтын ажиллагаа, нийслэл хотын өдөр, нийслэлийн шагнал, нийслэл хотын судалгааны байгууллагын талаар, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна. Үүнд:

Нийслэл хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, нийслэлийн төсвийг иргэдийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах, нийгэм, эдийн засгийн тулгамдаж байгаа асуудлыг эдийн засгийн аргаар шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлснээр улсын эдийн засаг, хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Нийслэл хотын хэт төвлөрлийг сааруулж, дагуул хотыг бий болгох түүнийг дагасан эдийн засгийн тусгай бүсийг төрөлжүүлэн хөгжүүлснээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот олон улсын хотуудын жишгийн дагуу эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн үндсэн төв болон хөгжих улмаар улсын эдийн нийгмийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд оршин суугчдын эрх ашгийг дээдлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, нийслэл хотын оршин суугч, хуулийн этгээдийн нийслэл хотын хөгжилд оролцох оролцоо нэмэгдэх, улмаар иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай оршин суух боломж нэмэгдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай,

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---oOo---